

МЭДЭЭ ТЭМДЭГЛЭЛ,
ЯРИЛЦЛАГА

**МОНГОЛ, АМЕРИКИЙН
ЭРДЭМТДИЙН ХОЁРДУГААР
БАГА ХУРАЛ**
(Шүүмж өгүүлэл)

Э. ПУНЦАГ

Америк, Зөвлөлт хоёр энэ оны (1988) зунаас эхлэн ойрын ба дунд тусгалын пуужингаа харилцан устгаж, цөмийн дэлбэлэлтийн хяналтыг хамтран турших болсон мэдээ ертөнцийн чихнээ ер бусын соргог агаад урамтай сонсогдох болсныг уншигч юун андах ажээ. Үүний нэгэн адил хэрэв Америк, Монголын эрдэмтэд хуралдаж, гэрээ протоколд гарын үсэг зурлаа* гэвэл тийм ч биелэгдэхгүй асуудал биш байсан нь одоо нэгэнт гайхаш төрүүлэхээсээ өнгөрчээ. Харин Монгол, Америкийн эрдэмтэд ингэж нэгэн ширээнээ сууж нүүр нүүрээ харж хоёр талын болон дэлхий дахины чанартай асуудлыг шүүн хэлэлцэх болсон нь өнөө үед олон улсын харилцааны уур амьсгал огцом өөрчлөгдөж буйн шинж тэмдэг даруй мөн бөгөөд улс төрийн шинэ сэтгэлгээтэй холбогдох нь гарцаагүй бизээ.

Монгол, Америкийн эрдэмтдийн ажил хэрэгч хэлхээ холбоонд тус хоёр орны хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосон явдал ихээхэн түлхэц үзүүлсэн нь эргэлзээгүй юм. Гэвч Монгол, Америкийн эрдэмтдийн анхдугаар бага хурал хоёр орны хооронд дипломат харилцаа** хараахан тогтоогүй байхад болсон нь нэг талаар тийм харилцаа тогтоно гэдгийг зөгнөсөн хэрэг болжээ.

Монгол, Америкийн эрдэмтдийн анхдугаар бага хурал 1986 оны 12-р сарын 17—19-нд АНУ-ын Калифорнийн их сургуулийн Дорнод Азийн судлалын институт дээр болж, Монголын талаас дөрвөн хүн оролцсон бол 1988 оны 6-р сарын 6—8-нд Улаанбаатарт болсон хоёрдугаар бага хуралд 15 эрдэмтэд оролцож, АНУ-аас 9 хүн хүрэлцэн ирж, манай талаас 8 илтгэл, америкийн талаас 6, бүгд 14 илтгэл сонсож хэлэлцсэн юм.

Улаанбаатарын монгол-америкийн эрдэмтдийн бага хуралд Монголын талаас түүхийн ухааны доктор Ш. Сандаг, Америкийн талаас Калифорнийн их сургуулийн Дорнод Азийн судлалын институтийн захирал, профессор Р. Скалапино нар үндсэн илтгэл тавив.

Хэлэлцсэн илтгэл бүр дээр санал нийлж байсан гэвэл мэдээж тийм биш бөгөөд гагцхүү ямар асуудлаар ямар учраас санал зөрж байна, яавал саналаа нэгтгэж, улмаар тухайн асуудлыг шийдвэрлэх ямар арга зам байна гэдгийг эрж сүвэгчлэхэд эрдэмтдийн зорилт оршиж байлаа. Монгол, Америкийн эрдэмтдийн хоёрдугаар бага хурал чухам ийм л уур

* 1988 оны 5-р сард АНУ-ын Нью-Жерси муж улсын Принстон хотноо БНМАУ ын Шинжлэх Ухааны Академи, АНУ-ын Шинжлэх Ухааны Нийгэмлэгүүдийн Зөвлөлийн хооронд хамтран ажиллах тухай протокол байгуулагджээ. (Монгол, Америкийн эрдэмтдийн хоёрдугаар бага хурлыг нээж ШУА-ийн ерөнхийлөгч, академич Н. Содномын хэлсэн үгнээс)

** Монгол, Америкийн дипломат харилцаа 1987 оны 1-р сарын 27-нд байгуулагдаж 1988 оны 9-р сарын 13-нд АНУ-аас БНМАУ-д суух анхны онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ричарт Л, Уильямс манай Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх-д итгэмжлэх жуух бичгээ гардуулсан билээ.

амьсгалын дунд болж өнгөрснийг тэмдэглүүштэй. Хоёр орны эрдэмтдийн бага хурлын ач холбогдол ч үүнд л оршиж байв.

Хоёрдугаар бага хуралд түүхийн ухааны доктор Ш. Сандаг тавьсан «Ази-Номхон далайн бүс нутаг: асуудлууд, улс төрийн шинэ хандлага» сэдэвт гол илтгэлдээ Ази, Номхон далайн аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар БНМАУ-ын явуулж байгаа үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй тайлбарлав. АНУ бол дэлхийн нэг том гүрний хувьд дэлхий дахинд, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт улс төрийн уур амьсгалд сайн муу аль тийш эргэхэд үзүүлэх их нөлөө бүхий учир бусад улсуудтай тухайн асуудлаар санал бодлоо солилцоход эрхбиш харилцан ойлголцохыг эрхэмлэн, огширч хуучирсан бодол, бахь байдаг дадал заншлаас зайлж, аливаад шинээр хандах цаг болсоныг илтгэгч тэмдэглээд Ази, Номхон далайн бүс нутгийн асуудлаар онцолж ярихдаа Кампучийг тойрон буй болсон асуудал, Солонгосын хойгийн сөргөлдөөнийг Афганистаных шиг улс төрийн хэлэлцээгээр шийдвэрлэж болох бүрэн боломж байгааг иш үндэстэй нотлов. Тэрээр Кампучид зарласан үндэсний эвлэрлийн бодлогыг талархаж, төвийг сахисан, эвсэлд үл нэгдэгч, ардчилсан Кампучийг цогцлон байгуулах, Солонгосын ард түмэн хойд, өмнөд хэсгээ энх тайван, ардчиллын үндсэн дээр гаднын ямар ч оролцоогүйгээр нэгтгэхэд саад тотгор хийхгүй байвал зохино гэв. Нэн даруй Өмнөд Солонгосоос гадаадын цэргийг татан гаргах хэрэгтэй. Тухайн үедээ гаднаас өнгөлзөн халдах аюул заналтай тулгарсан Афганистан, Монголд тэдгээрийн засгийн газрын хүсэлтээр ЗХУ хязгаарлагдмал тооны цэргээ, мөн адил зорилгоор БНСВУ-аас Кампучид цэргээ оруулсныг дэлхий нийтээр мэдэх бөгөөд одоо ЗХУ, БНСВУ дээрх орнуудаас цэргээ гаргаж эхэлсэн энэхүү сайн талын үлгэр жишээг АНУ авч хэрэглэмээр байна гэж Ш. Сандаг цохон тэмдэглэв.

Бага хуралд проф. р. Скалапино* «Ази-Номхон далайн олон улсын байдлын ерөнхий тойм, Номхон далайн өмнөд хэсэг дахь шинэ хандлага» сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв. Тэрээр Ази, Номхон далайн орнууд эмзэг хэврэг боловч итгэл төрүүлсэн үе рүүгээ орж байгаа тул тэрхүү орнуудын харилцааг жинхэнэ ёсоор сайжруулах хэрэгтэй байна гэв.

АНУ-ын азийн бодлого сүүлийн үед янз бүрийн шалтгаанаас болж хувьсан өөрчлөгдөж байгаа нь илт ажээ. Одоогоос яг л таван жилийн өмнө америкийн эрдэмтэн Х. Хардинг бичихдээ Хятад нь ЗХУ-ын эвслээс АНУ-ын эвсэлд шилжиж, олон улсын дэг журмыг эсэргүүцдэг байснаа больж, түүний төлөө тэмцэгч болсон нь дэлхийн II дайнаас хойш гарсан АНУ-д ашигтай үзэгдэл байв. Хятад 70-аад оны сүүлчээр АНУ, Өрнөд Европ, Японы талд (эвсэлд нийлэх тийш хандаж өнөө ч гэсэн (1983 он) Өрнөдтэй хагас эвслийн байдалтай байна гэж үзэж билээ.¹ Гэтэл Монгол, Америкийн эрдэмтдийн хоёрдугаар бага хуралд (1988) Хятадын гадаад бодлогын сүүлийн үеийн байдлаар биеэ даасан томоохон илтгэл тавьсан Брукингсийн институтын ахлах ажилтан д-р Хардинг хэлэхдээ Хятад нь хоёр их гүрэнд ижил зайнаас хандах болж

* Проф. Роберт А. Скалапино дэлхийн II дайны үед япон хэлтэй офицер явжээ. Тэр улмаар хятад хэл сурч Хятад, Зүүн ба Зүүн Өмнөд Азийн судалгаагаар мэргэжиж зөвхөн 1975 оны байдлаар 8 ном, 60 өгүүлэл бичиж түүнээс хойш өнөө хүртэл олон тооны өгүүлэл, ном зохиол бичиж олныг редакторложээ. Тэрээр АНУ ын засгийн газар, улс төрийн бодлого, олон улсын харилцааны сэдвээр бичсэн шилдэг ном зохиогчид олгодог В. Вильсоны нэрэмжит шагналыг 1974 онд хүртжээ. Р. Скалапино 1975 оны байдлаар гэхэд л Азийн районд 26 удаа айлчилсан бөгөөд тэнд амьдралынхаа сүүлчийн 25 жилийн гуравны нэг орчмыг өнгөрүүлжээ.

биеэ даасан бодлого явуулж, АНУ-тай үл эвсэлдэх байр суурь баримтлах боллоо гэж үзэж байна. Профессор Р. Скалагино ч мөн үзэл санааг хуваалцаж байгаа юм.

АНУ-ын улс төрийн бодлого судлаачид үзэхдээ Хятад бол ЗХУ-ын эвслээс гарч АНУ-ын эсвэлд шилжих тийш хандаж байснаа ийнхүү зогсож, АНУ-тай үл эвсэлдэх байрнаас харилцах болсон явдал АНУ-д тун ч ашиггүйгээр эргэв гэж үнэлж буй нь илэрхий. Профессор Р. Скалагино Ази тивд гарсан нааштай өөрчлөлтүүдийг хүлээсэн атлаа Зөвлөлт Хятадын харилцаа хэвийн болж байвч хойшдоо итгэл муутай гэж буйг нь тэрээр одоогоос 10 гаруй жилийн өмнө хятад-зөвлөлтийн харилцаанд нөлөөлөх сайн муу хүчин зүйлүүдийг хянаж үзээд, уг харилцаанд дараачийн арван жилд ч ахицтай өөрчлөлт гарах найдваргүй бололтой² гэж тооцоолсныг энд жишин үзэж болох байна.

1983 оны 12-р сард ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын институт дээр өнөө үе дахь Америкийн хятад судлал» сэдвээр хийсэн онол эрдэм шинжилгээний бага хурлаас А. Барнетт, Р. Торнтон, Р. Скалагино, Д. Загория нарын 1982—1983 оны зохиолуудыг судалж, үзээд, АНУ-ын хятад судлаачид зөвлөлт-хятадын харилцааг хэвийн болгохоос сүрхий болгоомжилж байгааг тодорхойлжээ.³

БНМАУ-ын ГЯЯ-ны орлогч сайд Х. Олзвой Монгол, Америкийн эрдэмтдийн хоёрдугаар бага хуралд «Ази, Номхон далайн бүс нутаг эдийн засгийн хамтын ажиллагаа» илтгэлдээ уг бүсийн орнуудын эдийн засаг, худалдааны харилцааг өргөтгөн хөгжүүлэх, шинэ хэлбэр агуулгаар баяжуулах бололцоо нөхцөл бүрэлдсээр байгаа нь 1980-аад оны нэг чухал онцлог юм гээд БНМАУ олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг шударга, ардчилсан замаар өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж байгааг тэмдэглэв.

Бага хуралд залуу эрдэмтэн Ц. Батбаяр, АНУ-ын д-р Сьюзан Шваб нар японы гадаад бодлогын холбогдолтой сонирхолтой илтгэлүүд тавьж хэлэлцүүлэв. Мөн өмнөд ба Зүүн Өмнөд Азийн асуудлаар дэд эрдэмтэн С. Дашцэвэл, АНУ-ын профессор Лео Розе нар нягт нарийн судалгаатай илтгэл хийлээ. Бага хуралд проф. П. Лувсандоржийн тавьсан «БНМАУ-ын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв», ШУА-ийн ДДСХ-ийн эрдэмтэн, Д. Дүнгэр-Яйчил, Л. Бэгзжав нарын тавьсан «Ази, Номхон далайн бүс нутгийн талаархи БНХАУ-ын гадаад бодлогын зарим асуудал», дэд эрдэмтэн Ч. Чойнхорын «БНМАУ-ын гадаад бодлогын санал, санаачлага», дэд эрдэмтэн С. Ишдоржийн «Монгол, Америкийн харилцааны товч тойм» зэрэг илтгэлүүд хуралд оролцогчдын анхаарлыг татаж тэдгээр сэдвийг тойруулан эрдэмтэд санал бодлоо өргөн солилцлоо.

Д. Дүнгэр-Яйчил, Л. Бэгзжав нар илтгэлдээ Ази, Номхон далайн бүс нутгийн байдал түгшүүртэй хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд Азийн төдийгүй, дэлхийн том гүрний нэг БНХАУ-ын гадаад бодлогын чиг хандлага чухал ач холбогдолтойг заан тэмдэглэлээ. Илтгэгчид БНХАУ-ын концепци, тухайлан Ази, Номхон далайн бүс нутгийн тулгамдсан асуудлаархи тус улсын байр суурьт гарсан зарим өөрчлөлтийг 80-аад оны байдлаар нягтлан тусгажээ. Хятад нь Азийн орны хувьд Азийн аюулгүй байдалд санаа тавихаа илэрхийлж тодорхой алхамууд хийхийн зэрэгцээ бүс нутгийн ба хөрш зэргэлдээ орнуудтай харилцаагаа сэргээж хэвийн болгоход чиглэсэн хүчин чармайлт тавьж буй онцлогийг дурдаад БНХАУ бүс нутгийнхаа орнуудтай хэвийн, сайн хөршийн харилцаа-

тай байвал олон улсын харилцаанд нааштай нөлөөлөх чухал хүчин зүйл болж чадна гэж үзлээ. Гэхдээ БНКАУ-ыг Хятадын засгийн газар өнөө хүртэл хүлээн зөвшөөрөхгүй атлаа Ардчилсан Кампучийн эвслийн засгийн газар гэгчийг бүх талаар дэмжиж буй нь Зүүн Өмнөд Азийн улс төрийн байдлыг тогтвортой болгоход тус дөхөм үзүүлэхгүй гэж тэд дүгнэв.

Бага хурал дээр хоёр орны эрдэмтдийн илтгэлүүдийг хэлэлцэх явцад зарчмын чанартай нэг бус асуудлаар санал зөрөөтэй байдал илэрч байсан бөгөөд тийм асуудлыг ч халз тулж илэн далангүй ярилцсан нь тус хурлын нэг онцлог боллоо.

АНУ-ын эрдэмтэд Ази, Номхон далайн бүс нутгийн ерөнхий төлөв байдал дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи аль ч үед одоогийнх шиг өөдрөг байгаагүйг тэмдэглээд, бүс нутгийн байдал ингэтэл сайжирч буйн шалтгааныг өөрсдийн байр сууринаас тайлбарлаж байлаа. Жишээ нь, д-р Хардингийн бодлоор БНХАУ Өрнөдийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн урамшуулахын тулд эдийн засагтаа бүтцийн өөрчлөлт хийх ёстой гэнэ. Үүгээр бол Хятад америкийн капиталд хөрөнгө оруулалтын болзол болгож одоогийнхоос илүү эрх дарх олгох ёстой болж байна.

Япон улс эдийн засгаа хохироож цэрэг зэвсгээр энэ зуунд битгий хэл, ирэх зуунд ч хөөцөлдөхгүй, зөвлөлтийн түвшинд хүрэхгүй гэж проф. Р. Скалапино хэлж байхад, д-р Загория Японыг цэрэгжүүлэхийг АНУ сонирхож байна гэж үзэж болохгүй гэж байна. Япон батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлж байгаа нь Москвагаас л болж байна гэж д-р Хардинг шууд мэтгэж байна. Америкийн эрдэмтдийн үзэж байгаагаар япон нь хэрэг дээрээ АНУ-ын ивгээлд оршиж байгаа ажээ. Японы «батлан хамгаалах» хүчин чадлыг нэмэгдүүлэхэд АНУ бүх талаар туслаж байна. Цаашилбал, хэрэв Японоос америкийн цэрэг гарвал Токио цэргийн зардлаа нэмэгдүүлж, хажуугаар нь Хятад цэрэгжиж, бас ЗХУ зэвсэглэлээр улам ч хөөцөлдөхөд хүрнэ гэж тэд үзэж байна. Үүнтэй холбогдуулан д-р Загория хийсэн мэдэгдэлдээ Ази, Номхон далайн бүс нутагт цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай Горбачевын санал нь тухайн бүс нутаг дахь гагцхүү АНУ-ын баазыг л устгахад чиглэсэн хэт өрөөсгөл шинж чанартай юм гэж өгүүлж байв. ЗХУ, Хятадын аль алинаас Япон айж, бусад орнууд Хятад болон Вьетнамаас эмээж буй тул АНУ-ын бааз тэнд хүч тэнцүүлж байгаа мэтээр тэд тайлбарлав

Нөгөө талаас америкийн зарим эрдэмтэд БНМАУ-ыг Тайваны нэгэн адил Хятадад дахин нэгтгэгдэх ёстой, Монголын тусгаар тогтнолыг Оросын цэргийн хүч хийгээд улс төрийн систем, эдийн засгийн дэмжлэгт бүрэн тулгуурлах явдлаар сольж авсан ёс төдий тусгаар тогтнол, МАХН нь үзэл суртлын маргаантай бүх асуудлаар Москвагийн чиг шугамыг бүхэлд нь тууштай баримталдаг нам гэх мэтээр үзэж байсан нь он цаг өнгөрөх тусам элэгдэн хуучирч, одоо болохоор БНМАУ, АНУ хоёр албан ёсоор хүлээн зөвшөөрөлцөж, дипломат харилцаатай болсныг дэмжиж ялангуяа Монгол, Америкийн эрдэмтдийн хооронд хэлхээ холбоо тогтооход бодит хувь нэмэр оруулахад нь огтхон ч саад тотгор болоогүй юм. Үүнээс үзэхэд АНУ-ын Азийн бодлогод ч, проф. р. Скалапино нарын Монголын тухай ойлголтод ч зарим талаар тодорхой, зарчмын чанартай өөрчлөлт гарч, шинэ, хуучин сэтгэлгээ зөрчилдөн, шинэ нь газар авч байна уу гэж бодуштай ажээ.

Проф. Люсьен В. Пай (АНУ) Зүүн Өмнөд Азийн ихэнх орны дотоод улс төрийн амьдралд өөрчлөлт гарч байгааг тэмдэглээд үүнийг АСЕАН, Вьетнамын хооронд үргэлжилсэн Кампучийн талаархи зөрөлдөөн намжих хандлагаас харж болно гэв.

Цаашилбал, Өмнөд Солонгос Умард Солонгосоос айж байгаа болохоор Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын цэргийн бааз оршиж байгаа нь бүс нутгийн хүчний тэнцүүрийг тохируулж байгаа юм гэж хуралд оролцсон америкийн эрдэмтэд үзэж байна. Тэд хэрэв Ази, Номхон далайн орнууд америкийн цэргийн баазуудыг нутгаасаа гаргах тухай асуудлыг одоогоор тавиагүй, хэрэв тийм асуудал цаашдаа тавибал АНУ харгалзаж үзэх л ёстой гэж үзэж байгаа нь нааштай хэрэг юм.

Тэд Солонгосын хойгийн асуудлаар бүх бурууг Пхеньянд албаар тохож, БНАСАУ-ыг дарангуйлан захирагч орон гэж үндэсгүй нэрлээд, түүнд Өмнөдийн эсрэг терроризм явуулж байна гэсэн сэтэр зүүлгэж байна. Тэд бас Зүүн Өмнөд Азид байдал төвөгтэй байгаагийн гол бурууг Вьетнамд түлхэж тус орныг цэрэг зэвсгэлэлээр хөөцөлдөж эдийн засгаа хайрахаа байсан учир хамгийн ядуу орон болж хувирлаа. Умард Солонгос ч гэсэн цэрэг зэвсгээс өөр бусад бүх салбарт Өмнөд Солонгосоос хол хоцорч байна гэж үздэг нь энэ бүс нутгийн түгшүүртэй байдлын бурууг бусдад тохох гэсэн хэрэг болжээ.

Америкийн эрдэмтэд Ази, Номхон далайн бүс нутгийн талаархи АНУ-ын бодлогыг хамгаалах байр сууринаас хандах нь мэдээж бөгөөд тиймээс ч энэ бүс нутгийн аюулгүй байдлын өнөөгийн шатны зарим нэгэн асуудлаар санал зөрөх явдал ч гарч байлаа.

Нөгөө талаар, Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж бэхжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг өрнүүлэх, улсуудын харилцан ойлголцох итгэлцэх явдлыг гүнзгийрүүлэх, энэ чигт хамтын хүч чармайлт тавих арга замыг хайх зэрэг асуудлаар монгол, америкийн эрдэмтдийн санал тохирч байгаа боловч хандлага өөр өөр байна.

Хэдий тийм боловч үзэл бодлоо чөлөөтэй, илэн далангүй солилцож, улмаар бие биенээ харилцан сайн ойлголцоход монгол-америкийн эрдэмтдийн бага хурал, уулзалт чухал ач холбогдолтой болохыг хоёр тал өндрөөр үнэлэв.

Монгол, Америкийн эрдэмтдийн цаашдын хамтын ажиллагаа, уулзалт, семинар, бага хурал ямар ч хэлбэрээр байсан, олон улсын харилцаа, улс төр, нийгмийн ухааны салбарын зэрэгцээ хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг нэгэн адил хамарч улам өргөжин хөгжинө гэдэгт найдаж байгаагаа хоёр орны эрдэмтэд санал нэгтэй илэрхийлээд, энэ удаагийн бага хурал уг зорилгод хувь нэмэр оруулсан чухал үйл явдал болсныг сайшаан тэмдэглэлээ.

1. "Problems of Communism". March-April, 1968. p. 1--13
2. "Asia and the Road Ahead", by Robert, A. Scalapino, Washington, 1975. p. 92
3. «Проблемы Дальнего Востока» 1984. No 1. с. 196.